



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-18, Факс: 32-70-18
E-mail: stategreatkhural@parliament.mn
http://www.parliament.mn

2024.12.20 № 45

Улсын Их Хурлын тогтоолын
хэрэгжилтийн талаар

Улсын Их Хурлын 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 16 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар "Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд Биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл"-ийг, 2 дугаар хавсралтаар "Төрийн өмчит банкны хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл"-ийг тус тус баталсан байна.

Улсын Их Хурлын 2022 оны 16 дугаар тогтоолоор батлагдсан төрийн өмчит хуулийн этгээдийн болон төрийн өмчит банкны энгийн хувьцааг нэмж гарган биржээр олон нийтэд нээлттэй худалдах замаар нээлттэй хувьцаат компани болгох "Үндсэн чиглэл"-ийн хэрэгжилттэй холбогдуулан;

Нэг. Төрийн өмчит 25 хуулийн этгээдийн хувьцааг биржээр олон нийтэд нээлттэй худалдах замаар нээлттэй хувьцаат компани хэлбэрт шилжүүлэх талаар:

Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд Биржээр олон нийтэд нээлттэй худалдах "Үндсэн чиглэл"-ийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д "Засгийн газар энэхүү Үндсэн чиглэлд заасан төрийн өмчит хуулийн этгээдийг нэмж хувьцаа гаргах, биржээр олон нийтэд нээлттэй арилжаалах ажлыг зохион байгуулж, үр дүнг Улсын Их Хуралд тайлагнах" гэж, 3.1.3-т "Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан журмын дагуу энгийн хувьцааг нийтэд санал болгох ажиллагааг Засгийн газар 2023 оны 06 дугаар сарын 30-ны дотор багтаан эхлүүлэх шийдвэрийг гаргах" гэж тус тус заажээ.

Мөн Засгийн газрын 2022 оны 244 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн мэдлийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт"-д тухайн компаниудын нийтэд нээлттэй худалдах хувьцааны хувь хэмжээ, хэрэгжүүлэх хугацаа, тайлбарыг тусгасан байна.

Дээр дурдсан Улсын Их Хурлын 2022 оны 16 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд Биржээр олон нийтэд нээлттэй худалдах Үндсэн чиглэл"-д тусгасан арга хэмжээнүүд нь тодорхой хугацаанд гүйцэтгэхээр тусгагдсан бөгөөд тогтоолын биелэлтийг хэрхэн зохион байгуулж, ямар үр дүнд хүрсэн, одоо хүлээгдэж буй үйл ажиллагаа зэргийг тодруулах шаардлагатай байна.

Хоёр. Төрийн банк хязгаарлагдмал хариуцлагатай компанийг хувьцаат компани хэлбэрт шилжүүлэх талаар:

Улсын Их Хурлын 2022 оны 16 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар Төрийн өмчит банкны хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах "Үндсэн чиглэл"-ийг баталсан бөгөөд Үндсэн чиглэлийг хэрэгжүүлснээр "Төрийн банк" хязгаарлагдмал хариуцлагатай компанийн нийт хувьцааны 20 хүртэлх хувийг үе шаттайгаар олон нийтэд нээлттэй арилжаалах нөхцөл бүрдэхээр зохицуулсан. Төрийн банкныг хувьцаат компани

2024000078

хэлбэрт шилжүүлэх хөтөлбөрийг “Үндсэн чиглэл”-ийн 3.1.1-д заасны дагуу Засгийн газар Монголбанктай хамтран батлан хэрэгжүүлж, үр дүнг Улсын Их Хуралд тайлагнахаар тусгасан байна.

Иймд Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 37 дугаар зүйлийн 37.1.2 дах хэсэг, Монгол Улсын Их хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 2022 оны Улсын Их Хурлын 16 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбогдуулан тогтоолын хавсралт тус бүрээр дараах асуулгыг тавьж байна. Үүнд:

Төрийн өмчит 25 хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд Биржээр олон нийтэд нээлттэй худалдах “Үндсэн чиглэл”-тэй холбогдуулан,


1. Үндсэн чиглэлд заасан төрийн өмчит хуулийн этгээдийг нэмж хувьцаа гаргах, биржээр олон нийтэд нээлттэй арилжаалах ажлыг хэрэгжүүлэхтэй холбоотой авсан арга хэмжээ, гарсан үр дүн, одоо хүлээгдэж буй ажил, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тулгарч буй асуудал, бэрхшээлийн талаар;
2. Үндсэн чиглэлийн 4.1 дэх хэсэгт заасан 25 төрийн өмчит хуулийн этгээд тус бүрээр тогтоолын биелэлтийг хангах үүднээс авсан арга хэмжээ, хөтөлбөр, ажлын гүйцэтгэл, бүрэн хэрэгжиж дуусах хугацааны талаар;

Төрийн өмчит банкны хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах “Үндсэн чиглэл”-тэй холбогдуулан,

3. Засгийн газар Монголбанктай хамтран Төрийн банкныг хувьцаат компани хэлбэрт шилжүүлэх хөтөлбөрийг баталсан эсэх, Хөтөлбөр батлагдсан бол түүний гүйцэтгэлийн талаар;
4. Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх үүднээс авсан арга хэмжээ, гүйцэтгэсэн ажил, ажлын явц, тулгарч буй асуудал, бэрхшээлийн талаар;

Энэхүү асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дах хэсэгт заасан хугацаанд бичгээр ирүүлэхийг хүсье.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



Д.ЭНХТҮВШИН

2024000078